



## Ерөнхийлөгчийн 2009 оны сонгуулийн Мониторингийн товч тайлан

2009 – 6 - 10

“Глоб Интернэшнл” ТББ сонгуулийн сурталчилгааны хамгийн идэвхтэй үе болох сүүлийн 15 хоногийн турш үндэсний хэмжээнд өргөн нэвтрүүлэг эрхэлдэг МҮОНТВ, UBS, ТВ-5, ТВ-9, 25 суваг телевизийн сонгуулийн сурталчилгаанд хийсэн мониторингийн товч тайланг танилцуулж байна.

Шударга сонгуулийн төлөө “Иргэний нийгмийн хяналт сүлжээ”-ний хүрээнд Нээлттэй Нийгэм форумын санхүүжилтээр хийсэн энэ мониторинг нь хамгийн нөлөөтэй ХМХ болох телевиз сүлжээний үндэсний хэмжээнд өргөн нэвтрүүлэг эрхэлдэг МҮОНТВ, UBS, ТВ-5, ТВ-9, 25 суваг телевизийн сонгуулийн сурталчилгаанд хийсэн мониторингийн товч тайланг танилцуулж байна.

Мониторингийн явцад тухайн телевизийн өргөн нэвтрүүлгийн нийт цагийг хамруулан тэнцвэрт байдал, сурталчилгааны өнгө аясыг судлахын зэрэгцээ, мэдээний хөтөлбөрийн тэнцвэрт байдал, мэргэжлийн түвшин, хэвлэл мэдээллийн нөлөөний тухай мэдээллийг үнэлж дүгнэв. Мониторингийг 2005 оны Ерөнхийлөгчийн, 2008 оны УИХ-ын сонгуулийн үеэр ашигласан, Словакийн МЕМО байгууллагын мэдээлэл цуглуулах, боловсруулах арга зүйн дагуу хийж, мэдээллийг дээрх байгууллагын өгсөн тусгай программаар боловсрууллаа.

Дурьдсан хугацаанд МҮОНТВ-ийн 239, UBS телевиз 270, 25-р суваг телевизийн 275, ТВ 5 телевизийн 282, ТВ 9 телевизийн 257 цагийн буюу бүгд 1324 цагийн нэвтрүүлэгт ажиглалт хийлээ. Форс мажор буюу цахилгааны хязгаарлалтын улмаас 5 телевизийн нийт 19 цагийн нэвтрүүлэгт ажиглалт хийгээгүй болно.

Сонгуулийн сурталчилгааны оргил үе буюу сүүлийн 15 хоногт 5 телевизээр нэр дэвшигчдийн талаар нийт 130 гаруй цагийн мэдээлэл цацагдсаны 52 орчим цаг нь мэдээний хөтөлбөрөөр, 79 орчим цаг нь мэдээний бус хөтөлбөрөөр дамжин олон нийтэд хүрсэн байна.

**Нэр дэвшигчдэд оногдсон цагийн хуваарилалт:** Нийт мэдээллийн 53% буюу 68:55:26 секунд нь Н.Энхбаярт, 47% буюу 61:54:37 секунд нь Ц.Элбэгдоржид ногдсон нь хувьчилсан үзүүлэлтээр нэлээд ойролцоо байгаа ч цагийг нарийвчлан хэмжихэд Н.Энхбаярт 7 цаг илүү оногджээ.

Телевизүүдийн мэдээний бус хөтөлбөрөөр дамжуулсан нэр дэвшигчдийн мэдээллийн 47% /37:29:56/ нь Н.Энхбаярын, 53% /41:44:26/ нь Ц.Элбэгдоржийн тухай байсан нь Ц.Элбэгдоржид илүү цаг хуваарилсныг харуулж байна. Харин мэдээний хөтөлбөрийн хувьд 61% /31:25:30/ нь Н.Энхбаяр, 39% /20:10:11/ Ц.Элбэгдоржийн тухай орсон нь цагийн хуваарилалт 2:5 харьцаатай байна.

**Нэр дэвшигчдийн талаарх мэдээллийн чанар:** Ерөнхийлөгчийн 2009 оны сонгуулийн сурталчилгааны нийт мэдээллийн 64% /83:42:30 секунд/ нь эерэг, 23% /29:49:53 секунд/ нь сөрөг, 13% /17:17:40 секунд/ нь төвийг сахисан мэдээлэл байжээ. Төвийг сахисан буюу туйлшраагүй мэдээлэл хамгийн бага хувь эзэлж байгаа нь сонгогчдод нэр дэвшигчдийн талаар үнэн бодит мэдээлэл авах боломж хомс байсан гэсэн дүгнэлтэнд хүрч байна.

Нэр дэвшигч Н.Энхбаярын мэдээллийн 79% /54:27:03 секунд/ эерэг, 13% /8:53:36 секунд/ төвийг сахисан, 8% /5:34:47 секунд/ нь сөрөг байсан бол Ц.Элбэгдоржийн мэдээллийн 47% /29:15:27 секунд/ эерэг, 14% /8:24:04 секунд/ төвийг сахисан, 39% /24:15:06 секунд/ нь сөрөг байлаа. Энэ нь сонгуулийн үеэр ХМХ-ээр нам, өрсөлдөгчид, нэр дэвшигчдийн өөрсдийн нь бэлтгэсэн, төлбөртэй сурталчилгаа давамгайлсныг харуулж байна.

Энэ сонгуулийн үеэр телевизүүдээр Н.Энхбаярын талаар эерэг мэдээлэл өрсөлдөгчийнх нь эерэг мэдээллээс 1,9 дахин их, харин нэр дэвшигч Ц.Элбэгдоржийн талаар сөрөг мэдээлэл Н.Энхбаярын талаарх сөрөг мэдээллээс 4.3 дахин их цацагджээ.

## **Телевиз тус бүрээр нь танилцуулъя.**

### **МҮОНТВ**

Сонгуулийн сурталчилгааны сүүлийн 15 хоногт МҮОНТВ-ийн нийт 14 365 минутын эфирт мониторинг хийхэд нэр дэвшигчдийн талаар 8:44:34 секундын мэдээлэл цацагдсан нь бусад телевизтэй харьцуулахад хамгийн бага цаг зориулсныг харуулж байна.

МАХН-аас нэр дэвшигч Н.Энхбаярын талаарх мэдээлэл нийт мэдээллийн 56%-ийг эзэлж байгаагаас эерэг мэдээлэл 36,5%, төвийг сахисан мэдээлэл 47,7%, сөрөг мэдээлэл 15,8% эзэлж байлаа.

АН-аас нэр дэвшигч Ц.Элбэгдоржийн талаарх мэдээлэл нийт мэдээллийн 44%-ийг эзэлж байгаагаас эерэг мэдээлэл 37,2%, төвийг сахисан мэдээлэл 41,6%, сөрөг мэдээлэл 21,2%-ийг эзэлж байлаа.

Нэр дэвшигчдийн мэдээллийн өнгө аясыг харьцуулахад Н.Энхбаярын талаарх эерэг мэдээлэл 55,5%, төвийг сахисан мэдээлэл 59,3% байгаа бол, нэр дэвшигч Ц.Элбэгдоржийн тухай сөрөг мэдээлэл 51,4%-ийг эзэлж байна.

### **ТВ 5 телевиз**

ТВ 5 телевизийн нийт 16 929 минутын эфирт мониторинг хийсэн ба нэр дэвшигчдийн талаар нийт 20:47:41 секундын мэдээлэл цацагджээ.

Нэр дэвшигч Н.Энхбаярын талаарх мэдээлэл нийт мэдээллийн 55%-ийг эзэлж байгаагаас эерэг мэдээлэл 69,7%, төвийг сахисан мэдээлэл 15,5%, сөрөг мэдээлэл 14,8 %-ийг эзэлж байлаа.

Нэр дэвшигч Ц.Элбэгдоржийн талаарх мэдээлэл нийт мэдээллийн 45%-ийг эзэлж байгаагаас эерэг мэдээлэл 48,7%, төвийг сахисан мэдээлэл 9,9%, сөрөг мэдээлэл 41,4% байлаа.

Нийт мэдээллийн өнгө аясыг харьцуулбал, Н.Энхбаярын талаарх эерэг 63,5%, төвийг сахисан мэдээлэл 65,5% байгаа бол, нэр дэвшигч Ц.Элбэгдоржийн тухай сөрөг мэдээлэл 69,7 хувийг эзэлж байна.

### **ТВ 9 телевиз**

ТВ 9 телевизийн 15 418 минутын эфирт мониторинг хийхэд нэр дэвшигчдийн талаар нийт 33:27:41 секундын мэдээлэл байжээ.

Нэр дэвшигч Н.Энхбаярын талаарх мэдээлэл нийт мэдээллийн 65%-ийг эзэлж байгаагаас эерэг мэдээлэл 88,1%, төвийг сахисан мэдээлэл 10,9%, сөрөг мэдээлэл 0,9%-ийг эзэлж байлаа.

Нэр дэвшигч Ц.Элбэгдоржийн талаарх мэдээлэл нийт мэдээллийн 35%-ийг эзэлж байгаагаас эерэг мэдээлэл 3,0%, төвийг сахисан мэдээлэл 17,9%, сөрөг мэдээлэл 79,1% байжээ.

Нийт мэдээллийн өнгө аясыг харьцуулахад Н.Энхбаярын талаарх эерэг мэдээлэл 98,2%, төвийг сахисан мэдээлэл 53,0% байгаа бол, нэр дэвшигч Ц.Элбэгдоржийн тухай сөрөг мэдээлэл 97,9%, төвийг сахисан мэдээлэл 47%, эерэг мэдээлэл 1,8 хувь байлаа.

## **UBS телевиз**

UBS телевизийн нийт 16209 минутын эфирт мониторинг хийснээс нэр дэвшигчдийн талаар нийт 30:25:01 секундын мэдээлэл цацагджээ.

Нэр дэвшигч Н.Энхбаярын талаарх мэдээлэл нийт мэдээллийн 62%-ийг эзэлж байгаагаас эерэг мэдээлэл 93,7%, төвийг сахисан мэдээлэл 5,5%, сөрөг мэдээлэл 0,8%-ийг эзэлжээ.

Нэр дэвшигч Ц.Элбэгдоржийн талаарх мэдээлэл нийт мэдээллийн 38%-ийг эзэлж байгаагаас эерэг мэдээлэл 85,1%, төвийг сахисан мэдээлэл 2,8%, сөрөг мэдээлэл 12,1%-ийг эзэлж байв.

Мэдээллийн өнгө аясыг харьцуулбал, Н.Энхбаярын талаарх эерэг мэдээлэл 64,0%, төвийг сахисан мэдээлэл 76,3% байгаа бол, нэр дэвшигч Ц.Элбэгдоржийн тухай эерэг мэдээлэл 36%, сөрөг мэдээлэл 90,5% байжээ.

## **25-р суваг телевиз**

MN-25 телевизийн сонгуулийн сурталчилгааны сүүлийн 15 хоногийн нийт 16 503 минутын эфирт мониторинг хийхэд нэр дэвшигчдийн талаар нийт 37:25:06 секундын мэдээлэл цацагджээ. Энэ үзүүлэлт нь мониторингид хамрагдсан телевизүүдээс хамгийн их цаг хугацааг нэр дэвшигчдэд зориулсан болохыг харуулж байна.

Нэр дэвшигч Н.Энхбаярын талаарх мэдээлэл нийт мэдээллийн 32% байгаагаас эерэг мэдээлэл 65.7%, төвийг сахисан мэдээлэл 11.4%, сөрөг мэдээлэл 22.9% байв.

Нэр дэвшигч Ц.Элбэгдоржийн талаарх мэдээлэл нийт мэдээллийн 68%-ийг эзэлж байгаагаас эерэг мэдээлэл 51.4%, төвийг сахисан мэдээлэл 13.6%, сөрөг мэдээлэл 35.0%-ийг эзэлж байлаа.

Мэдээллийн өнгө аясыг харьцуулахад Н.Энхбаярын талаарх эерэг мэдээлэл 37.9%, төвийг сахисан мэдээлэл 28.6% байгаа бол, нэр дэвшигч Ц.Элбэгдоржийн тухай эерэг 62.1%, төвийг сахисан 71.4%, сөрөг мэдээлэл 76.2 хувийг эзэлж байна.

## **Мэдээний хөтөлбөр**

Ерөнхийлөгчийн 2009 оны сонгуулийн үеэр телевизүүдийн мэдээний хөтөлбөрийн тэнцвэрт байдал, мэргэжлийн түвшинг тусгайлан судалсан юм.

Мэдээний хөтөлбөрүүдээр нэр дэвшигчдийн талаар нийт 51:35:41 секундын мэдээлэл түгээснээс 61% буюу 31:25:30 секунд Н.Энхбаярт, 39% буюу 20:10:11 секунд Ц.Элбэгдоржид хуваарилагдсан байна.

Мэдээний хөтөлбөрөөр олон нийтэд хүрсэн мэдээллийн чанар буюу өнгө аяс нь хоёр нэр дэвшигчийн хувьд харилцан адилгүй байжээ. Нэр дэвшигч Н.Энхбаярын мэдээллийн 83,1% нь буюу дийлэнх нь эерэг бөгөөд сөрөг мэдээлэл бараг байгаагүй (3,1%) бол, нэр дэвшигч Ц.Элбэгдоржийн тухай мэдээллийн 51,4% нь эерэг, 33,1% нь сөрөг байлаа. Телевизүүдийн мэдээллийн хөтөлбөрт Ц.Элбэгдоржид ногдох цаг 15 хоногийн турш өрсөлдөгчөөсөө 2-3 цагаар бага байсан төдийгүй сөрөг мэдээлэл нь давамгайлсан хэвээр буюу өрсөлдөгчөөсөө 6 дахин их байлаа.

Нэр дэвшигч Н.Энхбаярын тухай МҮОНТВ-ийн мэдээний хөтөлбөрөөр төвийг сахисан, ТВ-9, ТВ-5 телевиз эерэг мэдээлэл илүү давамгайлж байсан бол UBS, 25 суваг

телевизүүд нэр дэвшигчдийн талаар эерэг мэдээллийг, ТВ-9, ТВ-5 телевизүүд Ц.Элбэгдоржийн тухай сөрөг мэдээллийг илт илүү цацаж байжээ.

Мониторингийн хугацаанд мэдээний хөтөлбөрөөр нэр дэвшигчдийн тухай мэдээллийн 48% төлбөртэй шинжийг агуулсан мэдээлэл байсан нь телевизүүд мэдээллийн хөтөлбөрөө мэргэжлийн түвшинд бэлтгэн ажиллаж чадаагүйг харуулж байна.

### **Мониторингийн товч дүгнэлт**

Ерөнхийлөгчийн 2009 оны сонгуулийн сурталчилгаа санал хураах өдөр ойртох тусам идэвхжсэн байлаа. Харамсалтай нь, сонгуулийн сурталчилгаа төдийлөн тэнцвэртэй, шударга байж чадсангүй. “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагаас үндэсний хэмжээнд өргөн нэвтрүүлэг эрхэлдэг телевизийн таван сувгийн нийт 1324 цагийн эфирт хийсэн мониторингоос дараах үндсэн дөрвөн дүгнэлт хийж байна.

- Телевизийн сувгууд нэр дэвшигчдэд адил тэгш боломж олгосонгүй
- Монголын сонгогчид телевизийн сувгуудаар бодитой мэдээлэл авч чадсангүй. Нэр дэвшигчдийн тухай мэдээлэлд хэт нэг талыг барьсан, туйлширсан, өрөөсгөл байдал давамгайлсан байлаа.
- Телевизүүд сонгуулийн үеэр мэдээний хөтөлбөрөө мэргэжлийн түвшинд бэлтгэж чадсангүй. Мэдээний хөтөлбөрүүд мөн л сонгуулийн сурталчилгаа болон хувирч, нийт мэдээллийн бараг тэн хагас нь төлбөрт материалын шинж агуулсан байв. Төлбөрт мэдээлэл мониторингийн турш тогтмол өссөн байгаа нь сонгогчдын бодит мэдээлэл авах эрх хичнээн хязгаарлагдмал байсныг харууллаа
- МҮОНТВ арилжааны сувгуудтай харьцуулахад үүргээ зохих ёсоор биелүүлсэн байна.

Тоон үзүүлэлтийн нэгдсэн дүнг авч үзвэл, телевизийн сувгууд мэдээллийнхээ 53 хувийг МАХН-аас нэр дэвшигч Н.Энхбаяр, 47 хувийг АН-аас нэр дэвшигч Ц.Элбэгдоржид зориулсан нь зургаан хувийн зөрүүтэй, бараг тэнцвэртэй харагдаж байна. Мэдээний хөтөлбөрт Н.Энхбаярын тухай мэдээлэл 22 хувиар, бусад нэвтрүүлэгт Ц.Элбэгдоржийн тухай мэдээлэл 6 хувиар өрсөлдөгчөөсөө илүү байв.

- Харин сурталчилгааны тэнцвэрт байдал суваг тус бүрт хэтэрхий ялгаатай байсан нь телевизүүд мэргэжлийн түвшинд ажиллаж чадаагүйг харуулж байна. Тухайлбал, Ц. Элбэгдоржийн тухай мэдээлэл MN 25 сувагт 13 цагаар, Н.Энхбаярт зориулсан цаг TV9-д 10 цаг, UBS сувагт 17 цагаар тус тус өрсөлдөгчөөс нь илүү байна. Нэр дэвшигч Н. Энхбаярын тухай мэдээлэл TV5 сувагт хоёр цагаар илүү байсан нь арилжааны суваг дотроо харьцангуй тэнцвэртэй үзүүлэлт байв
- Мониторингид хамрагдсан телевизүүд нэр дэвшигчдийн тухай ихэнхдээ шууд бус мэдээлэл (82,1%) мэдээлэл дамжуулжээ. Шууд мэдээллийн 20,2 хувь Н.Энхбаярт, 15,3 хувь нь Ц.Элбэгдоржид ногдсон байна. Өөрөөр хэлбэл, телевизүүд нэр дэвшигчдийн тухай хэн нэгэн хоёрдагч, гуравдагч этгээд өөрсдөөс нь илүү ярьжээ
- Чанарын үзүүлэлтийн хувьд авч үзвэл, Нэр дэвшигчдийн тухай төвийг сахисан буюу бодит мэдээлэл 13 хувийг эзэлсэн байна. Сурталчилгааны үеэр Н.Энхбаярын талаар эерэг буюу хэт магтсан, дөвийлгөсөн мэдээлэл өрсөлдөгчийнхөөс нь 1,9 дахин их, харин нэр дэвшигч Ц.Элбэгдоржийн талаарх сөрөг буюу хэт муулсан, буруутгасан мэдээлэл Н.Энхбаярынхаас 4.3 дахин их цацагджээ
- Мэдээний хөтөлбөрийн чанарын үзүүлэлтийг авч үзвэл, Н.Энхбаярын тухай мэдээллийн 83.1 хувь нь эерэг, сөрөг мэдээлэл бараг үгүй буюу ердөө 3.1 хувийг эзэлсэн байна. Харин Ц.Элбэгдоржийн тухай эерэг мэдээлэл 51.4 хувь, сөрөг мэдээлэл нь 33.1 хувьтай байна. Хоёр нэр дэвшигчийн сөрөг мэдээллийг хооронд нь харьцуулахад 10 дахин зөрүүтэй байна.

## **МҮОНТВ**

Төрийн мэдлээс гарч, олон нийтийн болсон МҮОНТВ энэ жил анх удаа Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаанд оролцож, үүргээ зохих ёсоор биелүүлсэн байна. Хэдийгээр бүхий л ХМХ сонгуулийг хариуцлагатай мэдээлэх ёстой боловч олон түмнээс санхүүжиж буй олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд илүү өндөр шаардлага тавигдах нь зүйн хэрэг. ОИ МХ нь иргэдийн дадаадаар үйл ажиллагаа явуулдаг учраас аль нэгэн улс төрийн хүчин, хувийн ашиг сонирхолд бус харин олон түмний ашиг сонирхолд үйлчлэх хууль ёсны төдийгүй ёс суртахууны үүрэг хүлээдэг.

МҮОНТВ нэр дэвшигчдийн талаарх мэдээлэлд хамгийн бага цаг буюу нийт эфирийнхээ дөрвөн хувийг хуваарилж, төвийг сахисан мэдээллийн хэмжээ нь бусад телевизтэй харьцуулахад даруй 31-ээс 40 хувиар илүү байлаа. Нэр дэвшигчдийн тухай эерэг, сөрөг мэдээлэл нь хол зөрүүгүй байна Тэнцвэрт байдлыг тоон үзүүлэлтээр авч үзэхэд, хоёр нэр дэвшигчийн тухай мэдээллийн зөрүү нэг цаг буюу 12 хувьтай байлаа. Энэ нь МАХН-аас нэр дэвшигч Н.Энхбаярт ногджээ.

2009 оны 5 сарын 21-нд явуулсан нэр дэвшигчдийн халз ярилцлага сонгогчдын анхаарлын төвд байв. Мэргэжлийн үүднээс авч үзвэл, энэ нь халз ярилцлага гэхээсээ илүү урьдчилан бэлтгэсэн асуулттай, намуудад, нэр дэвшигчдэд хөтлөгдсөн гэмээр нэвтрүүлэг байсан ч хэт туйлширсан мэдээлэлд төөрөлдөж, бодит мэдээлэл хүсэж байсан сонгогчдод сонголтоо хийхэд нь ямар нэг хэмжээгээр тус болсон гэж үзэж байна.

**Утас:** 324764, 324627, **Факс:** 315326  
**И-мэйл:** [globenews@globeinter.org.mn](mailto:globenews@globeinter.org.mn)